

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн

2017 оны 12 дугаар сарын 31-нээр

дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2018/1/СТА-ЗГТС

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 10-наас 2018 оны 2 дугаар сарын 18-ны хооронд хийхээр төлөвлөн Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Д.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 26-нд аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 10-наас 2018 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 19-нд Аймгийн Нийгмийн даатгалын сангийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Тэтгэврийн даатгалын шимэтгэлийн нэрийн дансны тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Үйлдвэрлэлийн осол, мэргэлээс шалтгаалах өвчний тухай хууль, Мэдээллийн технологи программ хангамжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн

тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Байгууллагын зорилго нь: “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтөх, нийгмийн даатгалын шимтгэл төлүүлэх, санг бүрдүүлэх, зарцуулах болон нийгмийн даатгалын хууль, журам, тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх”

Зорилт нь: Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Байгууллагын дарга тус байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Байгууллагын 2017 оны төсвийг УНДЕГ-ын төсвийн багцаас болон тэтгэмжийн сангуудын шимтгэлийн орлогоос санхүүжүүлэн аймгийн Төрийн сан болон аймаг дахь арилжааны банкуудаар дамжуулан олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 19-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаанд УНДЕГ-аас баталсан “Нягтлан бодох

бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ажилласан байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй болон УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг НДСангийн НББ-ийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан баайна. Санхүүгийн тайланг нэгтгэхийн тулд ексел томъёогоор гараар оруулж, Пластик программд гараар шивж оруулж байгаа нь учир дутагдалтай ба цаашид НДСангийн тайланг шууд хөрвүүлж нэгтгэх программ шаардлагатай байгааг харуулж байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Аймгийн Нийгмийн даатгалын сангийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу УНДЕГ-аас аймгийн төрийн сангийн болон арилжааны банкууд дахь харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Тайлант оны ТГ тайлангаарх орлогын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөтэй болон өмнөх жилүүдийн үзүүлэлтийн дүнтэй харьцуулж шинжилж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг тодруулав.

Тайлант онд Нийгмийн даатгалын сангаас санхүүжих батлагдсан орлогын төлөвлөгөөг 85,5 сая төгрөгөөр илүү авсан бол эрүүл мэндийн даатгалын сангаас оруулах батлагдсан орлогын төлөвлөгөөг 163,2 сая төгрөгөөр тасалсан ба нийт дүнгээрээ 77,8 сая төгрөгөөр дутуу байна. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулвал орлогын гүйцэтгэл 4459,1 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Аймгийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн захирагч нь 2017 онд 52477,5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 52399,7 сая төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төсвөө 77,8 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу

хангаж ажиллах зорилгоор shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар алдаа, зөрчил илэрээгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан болон хяналтын горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого-санхүүжилт, мөнгөн хөрөнгө, тэтгэмжийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Ажил гүйлгээ их тул тус байгууллагын нийт орлогын 80 хувь, нийт зардлын 60 хувийг хамруулж нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг алдаа зөрчил илэрээгүй. Материаллаг бус дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1.Түүвэр сорил хийж үзсэн баримтуудаас ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой 9602,8 мянган төгрөгийн 15 ш, ҮОМШӨД Сангийн гүйлгээтэй холбоотой 24037,3 мянган төгрөгийн 9, Тэтгэмжийн даатгалын сангийн орлого ба зарцуулалтаар 21212,2 мянган төгрөгийн 11 бүгд 54852,3 мянган төгрөгийн 35 ажил гүйлгээний анхан шатны баримтыг дутуу бүрдүүлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дүгээр зүйлийн ... заалтуудыг зөрчиж ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хангаж ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж болгов.

2.Оны эцэст 846.0 сая төгрөгийн авлагтай гарч авлагын хэмжээ өмнөх оноос 515,5 сая төгрөгөөр буюу 155.9 хувиар нэмэгдсэн.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитад эрсдэлтэй гэж сонгосон дансуудын ажил гүйлгээг түүвэр сорилын аргаар тулган шалгасан. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар нарийвчлан шалгах шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг түвшингээс доогуур, санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл бага тул аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, менежементийн захидал ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо:2018.02.19

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
Огноо:2018.02.19

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАЗГҮЛ
Огноо:2018.02.18